

“НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИНЭЧЛЭЛИЙН ЖИЛ”-ИЙН ХҮРЭЭНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2023.12.05

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт
1.1	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс нийгмийн даатгалын шимтгэл төлдөг ажил олгогчийн судалгааг гаргаж, нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах	НДЕГ-аас ирүүлсэн чиглэл, хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс нийгмийн даатгалын шимтгэл төлдөг 272 аж ахуйн нэгж, 1-5 ажилтантай аж ахуйн нэгж 341 байгууллагуудын судалгааг гаргаж тус байгууллагуудын 2022, 2023 оны 03 дугаар сар
1.2	Хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бууруулж шимтгэл төлсөн ажил олгогчийн судалгаа гаргах,	дуусталх хугацааны санхүүгийн баримтад шалгалт хийлээ. Шалгалтад 18 байгууллага хамрагдлаа. Шалгалтаар салбарын хамтын хэлэлцээрт тусгасан доод хэмжээнээс доошгүй цалинжуулах хүргэж нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд даатгуулагчийн төрөл, ажил мэргэжлийн кодыг зөв тусгах, шимтгэлийн тайланг тоон гарын үсгээр илгээх талаар 6 албан шаардлага хүргүүлсэн. Зарим байгууллагуудын ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заавал тусгах нөхцөлүүдийн талаар ярилцан зөвлөгөө өглөө.
1.3	Нийгмийн даатгалын албан журмын даатгалд хамрагдсан 1-5 даатгуулагчтай ажил олгогчийн судалгааг гаргаж, нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажил зохион байгуулах	Шалгалтын үр дүнд барилгын үйл ажиллагаа явуулдаг “Их базар” ХХК-ийн ажилтнуудын цалингийн доод хэмжээг 05 дугаар сараас Барилгын салбарын хамтын хэлэлцээрт заасан хэмжээнд хүргэж тайлагнаж эхэлсэн. Мөн “Тал нутгийн сүлд”, “Дорнын мөнгөн сүлд”, “Цагаан сор” ХХК-ууд 6 дугаар сараас ажиллагсдын цалинг нэмэгдүүлэн тайлагнахыг даалгав.
1.4	Аймгийн Татварын хэлтсээс татвар төлөгч аж ахуйн нэгж байгууллагуудын судалгааг авах,	Аймгийн улсын бүртгэлийн хэлтсээс 2021-2023 онд шинээр бүртгүүлсэн 818 аж ахуйн нэгжийн нэрс, байршил, утасны дугаар, үүсгэн байгуулагчийн нэр зэрэг мэдээлэлтэй судалгааг авч 110 аж ахуйн нэгжийг нийгмийн даатгалд шинээр бүртгүүлэн ажиллалаа.

1.5	<p>Цалинтай ээж хөтөлбөрт хамрагдаж буй 0-3 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдийн судалгаа авч шимтгэл төлдөг эсэхийг хянан мэдээлэл сурталчилгаа хийх,</p>	<p>ХХҮГ-аас 2021-2023 онд төрсөн 4513 эх, үүнээс Хэрлэн сумын 1017 эхийн судалгааг авч зорилтот бүлгийн иргэдийг сайн дурын даатгалд хамруулах ажлыг зохион байгууллаа. Судалгаагаар:</p> <ul style="list-style-type: none"> • Ажил хөдөлмөр эрхэлж байгаа 393, • Сайн дурын даатгалын эхийн гэрээтэй 131, • Сайн дурын даатгал төлөөгүй 490, • 0-3 насны хүүдтэй боловч энгийн сайн дурын даатгалд хамрагдсан 2, • Регистрийн дугаар буруу 1 даатгуулагч байна. <p>Сайн дурын даатгал төлөөгүй 300 эхийн холбогдох дугаар руу дуудлага хийсэн үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> - Холбогдох боломжгүй 17 - Орох ярианы эрх хаагдсан 9 - Утасны дугаар буруу 4 эх - Одоогоор шимтгэл төлөх боломжгүй 27 - Амжилттай холбогдсон 243 эхэд нийгмийн даатгалын ач холбогдлын талаар мэдээлэл хүргэсэн байна. <p>Дээрх ажлын үр дүнд шинээр сайн дурын даатгалд 47 эхийг хамруулаад байна.</p> <p>Мөн “Дорнод” сонинтой хамтран ажиллаж сайн дурын даатгалын гэрээг цахимаар хийх, мөн шимтгэлийг хэрхэн төлөх , 0-3 настай хүүхдээ асарч байгаа эхийн шимтгэлийн 50 хувийн хөнгөлөлтийн талаар мэдээллийг өгч ажиллаж байна.</p>
1.6	<p>Малчид болон туслах малчин иргэдийн судалгааг сум тус бүрээр гаргаж нийгмийн даатгалд хамрагдаагүй иргэдэд сурталчлан таниулах ажил зохион байгуулах,</p>	<p>Туслах малчин иргэдийн судалгааг сум тус бүрээр гаргахад 159 туслах малчин ажиллаж байна. Судалгаанд хамрагдсан туслах малчдыг нийгмийн даатгалд хамруулах талаар мэдээлэл өгч ажиллан 61 малчныг нийгмийн даатгалд хамруулж 36.234,0 мянган төгрөгийн орлого санд оруулсан байна. Цаашид судалгааг тогтмол шинэчлэн нийгмийн даатгалд хамруулах талаар мэдээлэл зөвлөгөө өгч ажиллаж байна.</p>
1.7	<p>ISO 9001:2015 олон улсын стандартад нийцсэн чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх түгээх,</p>	<p>Стандарт хэмжил зүйн газраас зохион байгуулсан сургалтад оролцлоо. Сургалтаар ISO 9001:2015 стандартын талаар нэгдсэн ойлголттой болгох, цаашлаад байгууллагынхаа Чанарын удирдлагын тогтолцоог сайжруулах, хөндлөнгийн баталгаажуулалтын аудитад бэлтгэхэд зориулж ISO9001 стандартын модуль M1 ба M2 сургалтад хамрагдлаа. Ажилтнууд стандартын хэрэгжүүлэх төслийн 4 багт хувааж хэлтсийн хэмжээнд 1 дүгээр улиралд нэг удаа дотоод аудит хийсэн. Аудитаар илэрсэн 3 үл тохирлыг тухайн үед нь залруулга хийсэн.</p>



2.1	2022 онд нийгмийн даатгалын шимтгэлийн авлага үүсгэсэн аж ахуйн нэгж байгууллагын удирдлагатай уулзалт зохион байгуулах	<p>2022 оны жилийн эцэст үүссэн хуримтлагдсан авлагыг барагдуулах талаар төлөвлөгөө гаргаж батлуулан үе шаттайгаар бууруулах ажлыг зохион байгууллаа. Үүнд авлагын насжилтаар нь шатлан дараах ажлуудыг хийсэн.</p> <ul style="list-style-type: none"> - 31-60 хоногийн авлага үүсгэж улмаар шимтгэлийн өр төлбөрөө барагдуулаагүй байгаа 41 аж ахуйн нэгж байгууллагын удирдлагатай уулзалтыг зохион байгуулж гэрээ байгуулснаар 130574.4 мянган төгрөгийн авлагыг бууруулсан байна. - 61 дээш хоног авлага үүсгэсэн 16 ажил олгогчид улсын байцаагчаас албан шаардлага өч 16.242,5 мянган төгрөгийн шимтгэл оруулсан, - Мөн 50 аж ахуйн нэгж байгууллагын 575.747,1 мянган төгрөгийн авлагыг барагдуулахаар Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргаж ажилласан. <p>Дээрх ажлын үр дүнд 620.291,7 мянган төгрөгийн авлага бууруулж ажилласан болно.</p>
2.2	Ажил олгогч байгууллагын удирдлагууд, санхүүгийн ажилтнуудад шимтгэл төлөх талаар сануулах мессежийг хүргүүлэх,	<p>-Нийгмийн даатгалын байгууллага нь иргэд, даатгуулагч, ажил олгогчдод үзүүлэх үйлчилгээг цахимаар нэвтрүүлэн ажиллаж байгаатай холбогдуулан мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Дорнод аймгийн нийгэм, улс төр мэдээллийг сар тогтмол хэвлэн гаргадаг “ДОРНОД” сонинд ажил олгогч байгууллагад хандан нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг “Тоон гарын үсгээр” баталгаажуулан илгээх ач холбогдлын тухай мэдээлэл хүргүүлж нийтлүүлсэн байна.</p> <p>Мөн FACEBOOK групп чатаар мэдээлэл солилцож, шаардлагатай аж ахуйн нэгжийн удирдлагууд, санхүүгийн ажилтнуудтай утсаар холбогдон шимтгэл төлөх талаар сануулан байна.</p>
2.3	Аймгийн 2023 онд нийгмийн даатгалд шинээр хамруулах ажил олгогч, албан журмаар даатгуулагч, сайн дураар даатгуулагч, малчдын тооны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих	2023 онд нийгмийн даатгалд 74 ажил олгогч, 452 албан журмаар даатгуулагчийн шинээр хамруулах тооны төлөвлөгөөтэй байна. Жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 152 байгууллагын 513 албан журмын даатгуулагч, 895 сайн дурын даатгуулагчийг нийгмийн даатгалд шинээр хамруулаад байна.
2.4	Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулах ажлыг эрчимжүүлж шат дараатай арга хэмжээ авч ажиллах	2022 оны жилийн эцсийн байдлаар 80 байгууллага 658,540.6 мянган төгрөгийн шимтгэлийн өр үүсгэснээс 2023 оноос нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан ирүүлээгүй 25 байгууллагын 49,526.3 мянган төгрөгийн өрийг барагдуулахаар холбогдох албан тушаалтан, хаяг байршлыг тодруулах ажлыг эхлүүлэн ажиллалаа. Тус 25 байгууллагын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагааг Улсын бүртгэлийн хэлтсээс хуулийн дагуу хүргүүлэн авч эрэн хайх ажиллагаанд ашиглаж байна. Эзэн холбогдогч нас барсан Дорнын ариун хүнс ХХК нь 411,360 төгрөг, эзэн холбогдогч нь гадаадын иргэн

		<p>Чандмань тал майнинг ХХК-ны 927,000 төгрөгийн шимтгэлийн авлага барагдуулахад хуулийн хүрээнд хүндрэл учирч байна. Байгууллагын эзэдтэй холбогдсон боловч шимтгэлийн авлага барагдуулах боломжгүй байгаа 6 байгууллагын 14,077.7 мянган төгрөгийн авлага барагдуулахаар хуулийн байгууллагад холбогдох материалыг хүргүүлснээс 3 байгууллагын 7,268.5 мянган төгрөгийн авлага барагдуулсан байна. Үйл ажиллагаагаа түр зогсоож, татварын байгууллагад Х тайлан хүргүүлж байгаагаар албан бичгээр мэдэгдэж ирүүлсэн 7 байгууллага нь оны эцсийн үлдэгдлээс 15,330.3 мянган төгрөгийн авлагыг бүрэн барагдуулсан байна.</p>
3.1	<p>Нийгмийн даатгалын цахим үйлчилгээг нэмэгдүүлэх замаар нийгмийн даатгалын үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн даатгалын мэдээллийн санд бүртгэлтэй байгаа даатгуулагчдын мэдээллийн бүртгэлийг сайжруулах,</p>	<p>Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Цахим үндэстэн” болох арга хэмжээний хүрээнд Нийгмийн даатгалын байгууллага нь 23 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн, 12 үйлчилгээг төрийн цахим үйлчилгээний E-mongolia.mn-д холбоод байна. Мөн тайлант хугацаанд тэтгэмжийн үйлчилгээг 1718 иргэн цахимаар авсан ба хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг 1063, жирэмсэн амаржсаны тэтгэмжийг 655 иргэн авсан байна. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас ирүүлсэн чиглэлийн дагуу аймгийн нийт тэтгэвэр авагчийн хувийн хэргийг цахимжуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Нийт 14200 тэтгэвэр авагчийн хувийн хэргийг цахимжуулахаар ажилтнууд уртасгасан цагаар ажиллаж байна. Цахимжуулах ажил 75 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.</p> <p>Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн бүрдүүлэлтийг сайжруулах, даатгуулагчийн алдаатай бүртгэлийг залруулахад онцгой анхаарч энэ онд 23 даатгуулагчийн мэдээллийг залрууллаа. Ингэснээр төрийн мэдээлэл нь хоорондоо зөрөхгүй, иргэдэд үзүүлэх үйлчилгээ түргэн шуурхай, үнэн, бодитой байх боломж нөхцөл бүрдүүлэх юм.</p>
3.2	<p>Ажил олгогч байгууллагуудын хүний нөөцийн ажилтан болон санхүүгийн ажилтнуудад сургалт зохион байгуулах,</p>	<p>Татварын байгууллагатай хамтран аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр ангилан 4 өдрийн сургалт зохион байгууллаа. Сургалтад байгууллагын захирал, нягтлан бодогч, менежерүүд буюу нийт 80 төлөөлөгч оролцлоо.</p> <p>Сургалтаар нийгмийн даатгалын дэвтэр цахим болсноор мэдээллийн санд даатгуулагчийн анхан шатны бүртгэл, орсон гарсан тушаалыг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэж ажиллахыг байгууллагын хүний нөөцийн ажилтнуудад анхааруулж зөвлөн туслах ажлыг зохион байгууллаа.</p>
3.3	<p>Улсын байцаагчийн актаар нөхөн төлүүлсэн шимтгэлийг мэдээллийн санд оруулахдаа ХХТАО-ын дүн, нөхөн төлүүлэх хугацаа, үйлдвэрлэлийн ослын хувь, ногдуулсан шимтгэлийг нягтлан үнэн зөв бүртгэх</p>	<p>Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаагаар 90 байгууллага, иргэнд 83,4 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлж 31,7 сая төгрөгийн алданги, 9,0 сая төгрөгийн торгууль тооцож бүрэн барагдуулав.</p> <p>Тухайн акт төлбөрөөр нөхөн төлүүлсэн шимтгэлийг мэдээллийн санд</p>

оруулахдаа хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын дүн, нөхөн төлүүлэх хугацаа, үйлдвэрлэлийн ослын хувь, ногдуулсан шимтгэлийг тухай бүрд нягтлан шалгаж хяналт тавьж ажиллаж байна.

3.4 Даатгуулагчдад “Тэтгэмж авах хүсэлт”-ийн мэдээллийг сануулга мессежээр хүргүүлэх, хүсэлт авах ажлыг зохион байгуулах

НДЕГ-аас ирүүлсэн албан бичгийн дагуу цахимаар тэтгэмж авах хүсэлт илгээх талаар мэдээлэл дутмаг байгаа иргэдэд хэлтсийн цахим хуудсаар мэдээллийг тогтмол өгөхөөс гадна утсаар ярих, сануулга мессежийг тогтмол хүргүүлэн ажиллаж байна.
Үүнд: Давхардсан тоогоор хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах сайн дурын даатгуулагч 188 иргэн, жирэмсэн амаржсаны тэтгэмж авах 345 даатгуулагч иргэнд зөвлөгөө өгч ажиллалаа.
Жирэмсэн амаржсаны тэтгэмж авах даатгуулагч иргэн, сайн дурын даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудсыг эрүүл мэндийн байгууллагаас НДХ-т цахимаар илгээсний дараа даатгуулагч иргэд E-MONGOLIA төрийн үйлчилгээний нэгдсэн цахим системд өөрийн эрхээр нэвтэрч тэтгэмж авах хүсэлтийг илгээх талаарх мэдээллийг өгч ажиллалаа.
Мөн Дорнод сонинд “Тэтгэмж авах цахим хүсэлтийг илгээх” талаар мэдээлэл бэлтгэн нийтлүүлж ажиллав.
Аймгийн хэмжээний аж ахуйн нэгж байгууллагуудын нягтлан бодогч нарын фэйсбүүк группэд 7 хоног бүр даатгуулагч иргэдийн хөдөлмөрийн чадвар түр алдалтын эмнэлгийн хуудсыг хуулийн хугацаанд нийгмийн даатгалын байгууллагад ирүүлж байх талаар сануулах мессежийг илгээн ажиллав.



4.1	<p>“Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал, агуулга” сэдэвт хэлэлцүүлгийг ажил олгогч, даатгуулагчдад сурталчлан танилцуулах</p>	<p>“Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал, агуулга” сэдэвт хэлэлцүүлгийг ажил олгогч, даатгуулагчдад сурталчлан танилцуулах ажлыг сум, багуудад сумдын байцаагч нар тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Хэрэгжиж эхлэхтэй холбоотой бэлтгэл ажлыг ханган мэдээллийг иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад хүргэсээр байна.</p>
4.2	<p>0-3 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдэд нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаар сурталчлан таниулах постер бэлтгэж хэлтсийн вэб хуудсанд байршуулах</p>	<p>“Дорнод” сонинтой 2023 онд хамтран ажиллах гэрээ байгуулж 0-3 насны хүүхдээ асарч буй эхийн сайн дурын даатгалын шимтгэлийн 50 хувийг хөнгөлөх, “Туслах малчин, гэрийн үйлчилгээний ажилтан, тэдгээртэй адилтгах ажилтан нийгмийн даатгалд хамрагдах тухай”, “Тоон гарын үсгээр тайлан өгөх тухай”, “Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл”, “Нийгмийн даатгалд даатгуулах ач холбогдол”, “Сайн дурын даатгал” зэрэг сэдвээр мэдээлэл бэлтгэн 6 удаа сонинд нийтлүүлэв.</p> <p>Мөн орон нутгийн ТВ6 телевизтэй хамтран сайн дурын даатгалын талаар хариуцсан байцаагч 2 удаа мэдээлэл бэлтгэж хүргүүлсэн байна.</p> <p>Мөн хэлтсийн вэб сайтад ирсэн сайн дурын даатгалын холбогдолтой 12 асуултад хариулт өгч ажиллав.</p> <p>“Дорнод Нийгмийн даатгал” вэб сайтад ирсэн сайн дурын даатгалын талаарх иргэдийн асуултад хариулан шаардлагатай тохиолдолд утсаар нь холбогдон 193 даатгуулагч иргэнд сайн дурын даатгалын тооцоо, шимтгэл төлөлтийн талаарх мэдээлэл өгөв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> Сайн дурын даатгалын шимтгэл төлөх хэлбэр-66 Цахимаар даатгуулж гэрээ байгуулах тухай -56 Сайн дураар даатгуулагчийн гэрээгээр хүлээсэн шимтгэл төлөх үүргээ биелүүлээгүй-29 Шимтгэл төлөлтийн төлбөр тооцооны тухай-42 <p>Нийгмийн даатгалын ерөнхий газраас нийтэлж байгаа постер мэдээллийг Дорнод сайн дурын даатгуулагч фейсбүүк групп, хуудсаар түгээн ажиллаж байна. Оны эхнээс 15 мэдээллийг түгээсэн байна.</p> <p>-Шинэчлэн найруулсан “Нийгмийн даатгалын багц хууль”-ийн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн, тэтгэмжийн, ҮОМШӨ-ний тухай хуулийн агуулга</p> <ul style="list-style-type: none"> - Сайн дурын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд - 0-3 насны хүүхдээ асарч буй ээжүүдэд сайн дурын даатгалаа хөнгөлөлттэй нөхцөлөөр даатгуулах тухай гэх мэт
4.3	<p>Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн сурталчилгаа мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр байршуулах,</p>	<p>Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид орсон нэмэлт өөрчлөлт, болон нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг түргэн шуурхай хүргэхээр орон нутгийн МИЖИ, ТВ-6, Дорнод</p>

		<p>телевиз, Дорнод сонинтой, FM радио, цахим сувгаар хамтран ажиллаж иргэд, даатгуулагчдад хүртээмжтэй, өргөн цар хүрээтэй тогтмол мэдээ, мэдээллийг хүргэсэн гэж үзэж байна.</p> <p>"Дорнод аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс" фэйж хуудсаар дамжуулан иргэдээс ирүүлсэн асуултыг дор бүр нь хариултыг өгч ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар 232 иргэдийн асуултад хариулж зөвлөгөө мэдээллээр хангаж ажилласан.</p> <p>Нийгмийн даатгалын багц хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан НДЕГ-аас нийт ажилтнууд болон ажил олгогч, даатгуулагчдад сургалт зохион байгууллаа. Мөн хууль тогтоомжийн өөрчлөлтийг иргэд даатгуулагчдад сурталчилах 4 байцаагчийг сургагч багшаар бэлтгэн сертификат олгосон. Хуулийн шинэчилсэн найруулгын талаар "Нээлттэй хаалганы өдөр", сумдын "Малчдын зөвлөгөөн", "Нийгмийн цогц үйлчилгээ"-ний хүрээнд болон ажил олгогч даатгуулагчдад 22 удаагийн сургалтаар 1822 гаруй даатгуулагчдад мэдээлэл хүргээд байна.</p>
5.1	Хяналт шалгалтын байцаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг нь дээшлүүлэх сургалтад оролцуулах	<p>"Хяналт шалгалтын байцаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт" хэлтсийн 5 байцаагч хамрагдсан.</p> <p>"Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь төсөл"-ийн хүрээнд хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын хяналтын улсын байцаагчдыг чадавхжуулах сургалтад хамрагдсан 1 байцаагч хамрагдсан.</p> <p>Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаанд сайн туршлага нэвтрүүлсэн Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагааны мэдээллийг цахим уулзалтаар авч туршлага солилцов.</p> <p>2023 оны 12 дугаар сард зохион байгуулагдсан "Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа"-ны талаар эрх бүхий байгууллагаас холбогдох аж ахуй нэгж, байгууллагуудад нэгдсэн сургалтыг зохион байгуулав. Хэлтсээс удирдлага, тасгийн дарга нар, хяналт шалгалтын байцаагч нар бүрэн хамрагдаж ажиллалаа.</p>
5.2	Албан хаагчийн ёс зүй хандлагыг дээшлүүлэх, Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалтад хамруулах,	Төрийн албаны зөвлөлийн (7:4:10) вебинар сургалт "Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны эрх зүйн орчин" сургалтад хэлтсийн нийт албан хаагчид оролцов.

5.3	Сумын байцаагчдын ажлын арга туршлага, мэдлэг мэдээлэл хуваалцах, туршлага солилцох онлайн уулзалтыг зохион байгуулах	Сумын байцаагчдын ажлын арга туршлага, мэдлэг мэдээлэл хуваалцах, туршлага солилцох онлайн уулзалтыг 6 удаа зохион байгуулсан. Сургалтад: -Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн танилцуулга, хамрагдалтыг нэмэгдүүлэх, Зорилтот жилийн ажлын төлөвлөгөө хийж гүйцэтгэх ажил, - Пэйж хуудасны дагагчийг нэмэгдүүлэх уралдаан, мөн цахим үйлчилгээний талаарх мэдээлэл, - Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэл, өглөг авлага бусад тооцооны үлдэгдэл бууруулах талаар, -Тэтгэврийн нэмэгдэл, аргачлал бодох зааврын тухай. -Цахим шилжилт, эрүүл мэндийн даатгалын хамрагдалт, -Сум тус бүрийн байцаагчдын арга туршлагын талаар гэх мэт
5.4	Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны талаар сургалтад хамрагдах	Аймгийн Прокурорын газраас зохион байгуулсан "Дорнод аймгийн зөрчил шалган шийдвэрлэх байгууллагуудын хамтарсан зөвлөгөөнд 10 байцаагч хамруулав. Зөвлөгөөнд хамрагдсан байцаач ажилтнууд нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрхэн явуулах мөн хууль тогтоомжийн талаар мэдээлэл өгч хууль тогтоомжийн талаар асуулт бэлтгэн тест бөглүүлж үр дүнг тооцов.
5.5	Байцаагч, ажилтнуудын ёс зүй, харилцаа, хандлага, үйлчилгээний ур чадвар дээшлүүлэх сургалтад хамруулах	Байцаагч, ажилтнуудын ёс зүй, харилцаа, хандлага, үйлчилгээний ур чадвар дээшлүүлэх сургалтад хамруулах ажлын хүрээнд нийт ажилтнуудад 4 удаагийн цахим болон танхимын сургалтыг зохион байгуулахаас гадна төрийн албаны зөвлөлөөс Пүрэв гариг бүрд зохион байгуулдаг (4:7:10) сургалтад нийт байцаагч, ажилтнуудыг идэвхтэй хамрагдахыг уриалж, хяналт тавьж ажиллалаа.

НЭГТГЭСЭН:

БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТАН:

Б.ОТГОНЦЭЦЭГ